

モンゴル語

Гадаадын оршин
суугчдад зориулсан
заавар

Японд гэмт хэрэгт
холбогдолгүй, аюулгүй
амар тайван амьдрахын
төлөө.



Токио хот



Токио хотын Цагдаагийн газар



Токиогийн Цагаачлалын алба

Гарчиг

Танилцуулга

P1

Японы дүрэм, дэг журам

P2 ~ P5

Мэдвэл зохих Японы хууль, тогтоомж

P6 ~ P10

Дугуй унахад анхаарах зүйлс

P11 ~ P13

Ажил хийхэд анхаарах зүйл

P14 ~ P17

Оршин суугчийн үнэмлэхийн тухай

P18 ~ P20

Дунд болон урт хугацааны оршин суугчийн
хүлээсэн үүрэг, хариуцлагыг танилцуулах

P21 ~ P24

Танд ямар нэг асуудал гарвал хэнтэй
холбогдох - утас, хаяг

P25

Токиод амьдарч буй гадаадын иргэдэд

Токиод олон гадаадын иргэн амьдардаг.

Гэсэн хэдий ч зарим гадаадын иргэд хэл, соёл, амьдралын хэв маягийн ялгаанаас болж япончуудтай асуудал үүсгэдэг.

Нэмж дурдахад, Япон улсын хуулийг мэдэхгүй хүмүүс байдаг бөгөөд тэд буруу зүйл хийж буйгаа үл анзаарч, хууль зөрчдөг.

Гадаадын хүмүүст Японы хууль дүрэм, ёс журам, хууль тогтоомжийг ойлгож, аюулгүй, тав тухтай амьдрах боломжийг хангах зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулсан.



Японы дүрэм, дэг журам

◆ Хогоо хогийн саванд хаяна уу.



Хогоо зам дээр хаялгүй, хогийн саванд хаяна уу.

◆ Хог хаях дүрмийг чанд мөрдөнө үү.



Хог хаяхдаа, **хуваарьт өдөр, цаг, хаях газар, хог ялгалтыг** чанд мөрдөнө үү.



Том оврын хог зэргийг хууль бусаар хаяж болохгүй!
Сануулах гол зүйл

Том оврын хогийг хаяхдаа, оршин суугаа дүүргийн захиргаа (Хотын захиргаа)-наас тогтоосон хог хаях зааврыг дагаж мөрдөнө үү.

◆ Орон сууцанд амьдрахдаа, байр түрээслэх гэрээг сайтар сахиж мөрдөнө үү.



Байрны эзний зөвшөөрөлгүйгээр, цуг амьдрах хүний тоог нэмэх, бусдад дамжуулан түрээслэх, өрөөний хийцэд өөрчлөлт оруулах амьтан тэжээх зэргийг хориглоно!

Гэрээний нөхцлийг дагаж мөрдөөгүй бол хөөн гаргах тушаал гаргахад хүргэж болзошгүй.

◆ Байр, орон сууцны коридорт эд зүйлс тавихгүй байх.



Бусад хүмүүс мөн өрөөний гаднах коридор, шатыг ашигладаг.

Хэрвээ тэнд ямар нэгэн эд зүйл байвал гал түймэр, газар хөдлөлт болсон тохиолдолд та энэ аюулаас зугтааж, амь аврагдах боломжгүй болох талтай.

◆ Өрөөнд болон коридорт чанга дуугаар шуугилдаж,
хөгжим чанга тавьж сонсохгүй байх.



Чанга дуу хоолойгоор ярих, чанга дуу чимээ гаргах нь эргэн тойрны хүмүүсийг бухимдуулна.

Хэрэв та чимээ шуугиан гаргавал таныг цагдаад мэдэгдэж, та цагдаагийн ажилтнуудын анхааралд өртөх болно.

◆ Галт тэрэг болон автобусан дотор гар утсаар
ярих, чанга дуугаар ярихгүй байх.




Утсаа чанга яригч дээр тавьж ярих болон чанга дуу хоолойгоор ярих нь галт тэрэг, автобусанд зорчиж буй хүмүүсийн тайван байдлыг алдагдуулна.

Хэрэв та чимээ шуугиан гаргавал та асуудалд орж магадгүй.

Хүмүүсийн амьдарч буй газар болон олон хүн байгаа газарт та дүрэм, ёс журмыг дагаж мөрдөнө үү.

◆ 20 ба түүнээс дээш насны хүмүүс архи, тамхи хэрэглэхийг зөвшөөрнө.



Японд 20-с доош насны хүмүүс (20 нас хүрээгүй хүмүүс) архи ууж, тамхи татахыг зөвшөөрдөггүй.


◆ Тамхи татахыг зөвшөөрсөн газарт та тамхи татна уу.



Явган явж байхдаа эсхүл тамхи татахыг зөвшөөрсөн газраас өөр газар тамхи татаж болохгүй. Түүнчлэн, та зам дээр тамхины иш хаяж болохгүй. Токио хотын журмаар аливаа барилга байгууламж дотор тамхи татах хориотой.

Анхаарвал зохих Японы хууль

- ◆ Зорчих тасалбар, эрүүл мэндийн даатгалын картыг хүнд зээлэхгүй байх.



Бусдын хөнгөлөлттэй зорчих тасалбар, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, хувийн дугаарын картыг ашиглаж болохгүй.

Түүнчлэн өөрийн хөнгөлөлттэй зорчих тасалбар, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, хувийн дугаарын картыг бусдад зээлдүүлж болохгүй.

Энэ бол хууль зөрчсөн хэрэг тул та хариуцлага хүлээх болно.

- ◆ Хэрэв та ямар нэг эд зүйл олбол кообан (цагдаагийн хэсэг)-д авчирч өгнө үү.



Та олсон түрийвч, мөнгө, картыг өөрийн өмч болгож болохгүй.

Энэ бол хууль зөрчсөн хэрэг тул та хариуцлага хүлээх болно.

Хэрэв та ямар нэгэн зүйл алдсан, гэсэн бол алдсан, гэсэн зүйлийн талаарх мэдэгдлийг илгээнэ үү.
Алдагдсан, гэсэн зүйл тань олдвол буцаан олгогдох болно.

◆ “Хулгай” бол гэмт хэрэг юм.



“Хулгай” гэж барааны мөнгийг төлөлгүй, дэлгүүрээс уг барааг авч явах үйлдлийг хэлнэ.

Хулгай хийх, хулгайн эд зүйлийг зөөвөрлөх, харуулдах, хулгайчийг зугтан зайлахад туслах үйлдлүүд нь бүгд гэмт хэрэгт тооцогдоно.

Японы дэлгүүрүүд хамгаалалтын камертай байдаг бөгөөд харуул хамгаалалтын ажилтнууд түүнийг хянаж байдаг.

Та хэзээ ч дэлгүүрээс хулгай хийж болохгүй.

◆ Бусад хүний тавьсан дугуйг унаж явахгүй байх, энэ нь хаягдсан, эзэнгүй байсан ч гэсэн авч явж болохгүй.



Буудал эсхүл зам дээр байгаа дугуйг авч явж болохгүй.

Энэ бол хууль зөрчсөн хэрэг тул та хариуцлага хүлээх болно.

◆ Бусдын тариалангийн талбайн ногоо болон жимс, малыг хулгайлж болохгүй.

◆ Зөвшөөрөлгүйгээр гол, далайгаас загас, хясаа барьж болохгүй.

◆ Аюултай зүйл биедээ авч явахгүй байх.



Хутга болон нулимс асгаруулагч бодис

Ямар ч шалтгаангүйгээр хутга зэрэг аюултай зүйлсийг биедээ авч явж болохгүй.

Энэ бол хууль зөрчсөн хэрэг тул та хариуцлага хүлээх болно. Дараахь зүйлс бол аюултай ачаа авч явах шалтгаан биш юм.

- Өөрийгөө хамгаалах шалтгаанаар танд энэ зүйл байсан
- Танд тааламжтай, эвтэйхэн байсан гэж бодсон учраас та үүнийг авч явсан
- Энэ нь дэгжин, ганган, загварлаг гэж бодсон
- Өмнө нь үүнийг ажил хийж байхдаа эсхүл аялж амарч байхдаа хэрэглэж байсан боловч түүнийг цааш нь далд хийхэд төвөгтэй байсан болохоор цүнхэндээ үлдээсэн байсан.

◆ Хууль бусаар мансууруулах бодисыг хадгалах, хэрэглэх нь гэмт хэрэг юм.



Япон улсад дараах мансууруулах бодисыг хадгалж, хэрэглэж болохгүй.

- Сэргээгч бодис
- Каннабис (марихуан)
- Кокаин
- Героин
- Метил эдиокси метамфетамин
- Аюултай мансууруулах бодис гэх мэт


Ганц удаагийн хэрэглээ ч гэсэн гэмт хэрэг юм.

Хэзээ ч үүнийг хадгалж, хэрэглэж болохгүй.

Эдгээр зүйлсийг Японд авчрах нь бас гэмт хэрэг юм.

◆ Дараах үйлдлийг гэмт хэрэгт тооцно!
Амархан мөнгө олно гэсэн амлалт, ухуулгатай
ажлаас болгоомжилно уу.

- Гар утас, банкны карт, банкны дэвтрийг хүнд зарах, дамжуулах.




- Гар утас, банкны дансыг өөр хүний өмнөөс гэрээ хийх.




- Өөр хүний кредит карт ашиглаж, интернетээр бараа захиалах.



- Бусад хүний банкны карт ашиглан мөнгө гаргаж авах.




- Өөр хүний нэрээр шуудан ачаа хүлээж авах. Хүнд дамжуулах эсхүл тогтоосон газар руу дамжуулах явуулах.



Бусад хүний өмнөөс ачаа хүлээж авах. Тогтсон газар руу шилжүүлж явуулах.

- Дотор нь юу байгааг нь мэдэхгүйгээр дугтуй эсхүл ачаа тээшийг бусад хүмүүсээс аваад, түүнийг асуусан хүмүүст нь дамжуулж өгөх.



Болгоомжтой байгаарай!

Эдгээр үйлдлийн цаана зохион байгуулалттай гэмт хэрэг нуугдаж байдаг.


Хүмүүс өөрөө мэдэлгүй гэмт хэрэгт орооцолдож магадгүй.

Амархан мөнгө олно гэсэн сэтгэлдээ хөтлөгдөн, аливаа зүйл холбогдохгүй байх.



Дугуй унахад анхаарах зүйлс

- ◆ Дугуй худалдаж авах болон хүнээс хүлээн авахдаа баримт авах, бүртгэлд хамрагдана уу.



Дугуй худалдаж авахдаа

Хүнээс дугуй авсан үед

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүртгэлд шинээр бүртгүүлэх хэрэгтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүртгэлийн эзэмшигчийн нэрийг өөрчлөх шаардлагатай.

"Унадаг дугуйн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүртгэл" гэсэн тэмдэгтэй газар эсхүл унадаг дугуйны худалдаа эрхлэгчид байдаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүртгэлд та бүртгүүлж болно. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүртгэл дээрх нэрээ өөрчлөхийн тулд танд хураамж төлбөр, оршин суух үнэмлэх, унадаг дугуйн аюулгүй байдлын бүртгэлийн карт (хэрэв байгаа бол) шаардлагатай болно.

- ◆ Дугуйг дугуйны зогсоолд тавина уу.



Дугуйг дугуйны зогсоолд тавилгүй, галт тэрэгний буудлын өмнө дур мэдэн тавивал хураагдах болно! Хураагдсан дугуйг буцааж авахын тулд, хураамж төлбөр төлөх шаардлага гарна.

◆Японд, автомашинтай адил хууль дугуйнд үйлчилнэ!

Унадаг дугуйгаар аюулгүй явах таван дүрэм

- 1 Унадаг дугуйны хувьд автомашины замын хөдөлгөөний дүрэм баримтална, явган хүний замаар дугуйтай явж үл болно.



Дараах тохиолдолд явган хүний замаар явж болно.

- Явган хүний зам дээр "Ердийн унадаг дугуйг зөвшөөрнө" гэсэн тэмдэг байвал
- 13 нас хүрээгүй хүүхэд, 70-аас дээш насны өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн унадаг дугуйгаар явж байгаа тохиолдолд
- Замын засвар зэргээс шалтгаалан автомашины замын зүүн талаар явж болохгүй байх тохиолдолд



- 2 Автомашины замын зүүн талыг барьж явах ёстой.



Унадаг дугуйгаар авто замаар явахад энэ нь автомашинтай адил зүүн гарын замын хөдөлгөөний дүрэм үйлчилнэ. Баруун гар талыг баримтлах замын хөдөлгөөнийг хориглоно.

- 3 Явган хүний замаар явахдаа явган хүнийг хүндэлж, замын захаар аажуу явна.



Явган хүний замаар унадаг дугуйгаар явахдаа зам дээр даруй зогсох боломжтой хурдаар явна уу. Хэрэв та явган зорчигчдын гарцыг хаасан бол түр зогсолт хийгээрэй.

- 4 Аюулгүй байдлын дүрмийг сахих.



Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ дугуй унахыг хориглоно



Дугуйн дээр сундалдаж явахыг хориглоно



Зам сүлжин хайвганаж явахыг хориглоно



Шүхэр дэлгэнгээ дугуй унах хориотой



Шөнө явахдаа гэрлээ асаах.



Уулзвар дээр замын хөдөлгөөний гэрлэн дохиог дагаж мөрдөх, түр зогсож, аюулгүй байдлыг шалгах.

- 5 Хамгаалалтын малгай өмсөх.

Токиод, дугуй унахад, хамгаалалтын малгай өмсөх шаардлагатай.



◆ Токио хот дотор дугуй унах тохиолдолд ослоор бусдын амь нас эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд зориулсан албан журмын даатгалд хамрагдсан байх шаардлагатай.

Ажил хийхэд анхаарах зүйл

- ◆ Цагийн ажил хийхэд визний ангиллын гадуур үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг урьдчилан авна уу.



Гадаадын иргэд Цагаачлалын хяналт, дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх тухай хуульд заасны дагуу оршин суух статусынхаа хүрээнд Японд ажил хийхийг зөвшөөрнө.

Дараах тохиолдолд мэргэшсэн бус үйл ажиллагааны зөвшөөрлийг урьдчилан авна уу.

- "Оюутан" эсхүл "Гэр бүл"-ийн оршин суух статустай гэх мэт Японд ажил хийхийг зөвшөөрдөггүй хүн цагийн ажил хийх.
- "Технологи, хүмүүнлэгийн мэдлэг, олон улсын үйлчилгээ" гэх мэт Японд ажиллах зөвшөөрөлтэй хүмүүс оршин суух статуст заасан үйл ажиллагаан дээр нэмээд цагийн ажил хийх.



Болгоомжтой байгаарай!

Мэргэшсэн бус үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлд цагийн хязгаарлалт байдаг.

Мэргэжлээс гадуур цагийн ажил хийх зөвшөөрөлгүйгээр эсхүл хязгаарлалтыг дагаж мөрдөхгүйгээр цагийн ажил хийж болохгүй.

Энэ бол хууль зөрчиж байгаа хэрэг тул та хариуцлага хүлээх ба танд бүр албадан гаргах арга хэмжээг авах боломжтой!



NO!

◆ Ажиллах эрхийн бичиг авч цагийн ажил хийх тохиолдолд, долоо хоногт 28 цагаас дээш ажиллахгүй байх.



2-оос дээш өөр өөр газарт ажилласан ч долоо хоногт нийт 28 цагийн дотор ажиллах хэрэгтэй.

*“Гадаад оюутан”-ы визээр сурч байгаа хүн, сургуулийн дүрэмд заасан урт амралтын үе (Зуны амралт, өвлийн амралт зэрэг)-д 1 өдөрт 8 цаг (долоо хоногт хамгийн дээд хэмжээ 40 цаг) ажиллаж болно.

◆ Ажиллах эрхийн бичиг авч цагийн ажил хийхдээ, садар самуун сурталчлах газарт ажиллаж болохгүй.



Та дараах газарт цагийн ажил хийж болохгүй.

- Хөнгөн зуушны газар, кабаре, уушийн газар, интертэйнмэнт клуб гэх мэт үйлчлүүлэгчиддээ урлаг соёлын үзүүлбэр, хоол, уух зүйл санал б олгодог газрууд
- Цахим тоглоомын газар
- Даалуу тоглоомын газар
- “Pachinko” тоглоомын газар
- Love hotels буюу бэлгийн хавьталд зориулсан зочид буудал
- Телефон клуб
- Deai kissa буюу эсрэг хүйстэн танилцахад зориулсан кафе
- Насанд хүрэгчдэд зориулсан бараа зардаг дэлгүүр
- Насанд хүрэгчдэд зориулсан видео бичлэг зардаг дэлгүүр
- Тусгай өрөөтэй видео дэлгүүр
- Хүүхэн дуудлагын үйлчилгээ бизнес

Ийм газарт таныг бүр цэвэрлэгч, аяга угаагч, зөөгч, танхи мын ажилтан гэх мэт ажил хийхийг ч зөвшөөрдөггүй.

◆ Ажиллах эрхийн бичиг авч цагийн ажил хийхэд, садар самууныг сурталчлах газартай ижил төстэй газруудаас болгоомжлох хэрэгтэй.



Та сексийн үйлчилгээ үзүүлдэг массажны газар эсхүл үйлчлүүлэгчийн хажууд сууж ярилцаж, согтууруулах ундаа хамт уудаг ресторанд ажиллаж болохгүй.

Тэр ч бүү хэл ийм төрлийн газарт ажилладаг хүн зүгээр гэж хэлсэн ч та бүү итгэ.

Та насанд хүрэгчдийн зугаа цэнгээний газарт ажиллаж байсан гэдгээ мэдээгүй байсан ч танд хариуцлага хүлээлгэж, тус улсаас албадан гаргана.

◆ Сургуулиасаа гарсны дараа цагийн ажил хийж болохгүй.



Олон улсын оюутан сургуулиа хаясан эсхүл сургуулиасаа хасагдсан шалтгаанаар сургуулиа орхисон тохиолдолд цагийн ажил хийхийг хориглоно.

Оршин суух хугацаа болон Мэргэшлийн бус үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байсан ч цагийн ажил хийхийг хориглоно.

Хэрэв сургуулиасаа гарсны дараа цагийн ажил хийсэн бол хариуцлага хүлээлгэх эсхүл Япон улсаас албадан гаргана.

◆ Ажил олж өгнө гэсэн нэрийдлээр бүртгэлийн хураамж нэхэмжилсэн газраас болгоомжил.



Гадаадын иргэнд цагийн ажил олж өгнө хэмээн хууран мэхэлж, бүртгэлийн хураамж хэлбэрээр мөнгө залилж авдаг гэмт хэрэг гардаг.

Бүртгэлийн хураамж, лавлагаа өгөх үйлчилгээний хураамж гэх мэтээр мөнгө авах гэсэн хүмүүсээс болгоомжлох хэрэгтэй.

◆ Зөвшөөрөл авахгүйгээр амьдарч буй байраа төлбөртэй түрээслэхийг хориглоно.



Аялагчдыг гэртээ төлбөртэй байрлуулахын тулд харьяа эрүүл мэндийн төвөөсөө зөвшөөрөл авах шаардлагатай, эсхүл мужийн засаг захиргаа, хотын захиргаанд мэдэгдэх хэрэгтэй.

Хэрэв зөвшөөрөлгүй орон байраа бусдад түрээслэсэн бол хариуцлага хүлээлгэнэ.

Оршин суух үнэмлэхийн тухай

- ◆ Гадуур явах тухай бүртээ оршин суух үнэмлэхээ байнга биедээ авч явах шаардлагатай.



Оршин суух үнэмлэхийг Японд удаан хугацаагаар оршин суудаг гадаадын иргэдэд олгодог.

Та оршин суух үнэмлэхтэй байх ёстой.

Оршин суух үнэмлэхгүй байх нь хууль зөрчсөн үйлдэл тул танд мөнгөн торгууль ногдуулна.

Та паспорт эсхүл эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ гэх мэт биеийн байцаалттай байсан ч оршин суух үнэмлэхтэй байх ёстой.

Оршин суух үнэмлэх авах боломжтой хүмүүс ("Дунд болон урт хугацаанд оршин суух") гэж дараах ①-ээс ⑦ ангиллын аль нэгэнд багтаагүй хүмүүсийг хэлнэ.

- ① 3 сараас доош хугацаанд оршин суух статустай хүн
- ② Богино хугацааны оршин суух статустай хүн
- ③ Дипломат буюу "албан ёсны" оршин суух статустай хүн
- ④ Япон дахь Тайван-Японы Харилцааны Нийгэмлэгийн ажилтнууд (Тайпейн Эдийн засаг, соёлын төлөөлөгчийн газар гэх мэт), эсхүл Япон дахь Палестины Ерөнхий Газрын ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд.
- ⑤ "Тодорхой үйл ажиллагаа" (Дижитал номад (олон улсын зайнаас хийх ажил зэрэг зорилгоор Япон улсад оршин суух хүн) болон түүний эхнэр/нөхөр, хүүхэд)-ны оршин суух статус олгогдсон хүн
- ⑥ Тусгай байнгын оршин суугчид
- ⑦ Оршин суух статусгүй хүмүүс


◆ Цагдаагийн байгууллага эсхүл Цагаачлалын албаны ажилтан таны оршин суух үнэмлэхийг шалгахыг хүссэн тохиолдолд шалгуулах үүрэгтэй.



Цагдаагийн алба хаагч гадаад иргэдийг оршин суух үнэмлэхээ шалгуулахыг хүссэн тохиолдолд шалгуулах үүрэгтэй.

Цагдаагийн албан хаагчийн хүсэлтийн дагуу оршин суух үнэмлэхээ шалгуулаагүй тохиолдолд танд хариуцлага хүлээлгэнэ.

◆ Оршин суух үнэмлэх хүчинтэй хугацаатай байдаг.



- "Байнгын оршин суугч" / "2-р ангиллын өндөр ур чадвартай мэргэжилтэн" гэсэн оршин суух статус

16-аас дээш насны хүн: олгосноос хойш 7 жилийн хугацаанд хүчинтэй.

16-аас доош насны хүн: 16 насны төрсөн өдрийн өмнөх өдөр(*) хүртэл

- "2-р ангиллын өндөр ур чадвартай мэргэжилтэн" гэсэн ангилалд багтаагүй бусад оршин суугчид

16-аас дээш насны хүн: Оршин суух хугацаа дуусах хүртэл

16 наснаас доош насны хүн: Оршин суух хугацаа дуусах өдөр эсвэл

16 насны төрсөн өдрийн өмнөх өдөр(*) -ийн аль түрүүлж болох өдөр хүртэл

*2023 оны 10 сарын 31-ний өдрийг хүртэл олгогдсон оршин суух үнэмлэхэд "16 насны төрсөн өдөр" гэж заасан.


- ◆ Хэрэв та оршин суух үнэмлэхээ хаяж гээгдүүлсэн бол нэн даруй Цагаачлалын албанд мэдэгдэж, дахин үнэмлэх авах өргөдөл гаргана.



Дахин үнэмлэх авах хүсэлт гаргахдаа хаяж гээгдүүлсэн гэсэн нотолгоо (алдсан үнэмлэх, хулгайлагдсан үнэмлэх, гамшгийн гэрчилгээ гэх мэт), паспорт, гэрэл зургаа хавсаргах шаардлагатай. Орон нутгийн цагаачлалын албанаас урьдчилан асууж лавлана уу.

Хэрэв 14 хоногийн дотор дахин үнэмлэх авах хүсэлт гаргаагүй бол хариуцлага тооцно.

- ◆ Оршин суугчийн үнэмлэхийг өөр бусад хүнд өгөхгүй, зээлдүүлэхгүй байх.



Зээлдүүлэхгүй! Бусад дамжуулахгүй!

Ямар зорилгоор ашиглах гэж байгааг нь үл мэдэх тохиолдолд оршин суух үнэмлэхээ бусад зээлдүүлж эсхүл өгөхийг хориглоно.

Таны оршин суух үнэмлэхний хугацаа дууссан байсан ч бусад зээлдүүлж болохгүй. Энэ нь хууль зөрчсөн үйлдэл тул танд хариуцлага тооцож эсхүл тус улсаас албадан гаргана.

Хуурамч эсхүл өөрчилж засварласан оршин суух үнэмлэх авахаас болгоомжил!

Ашиглах зорилгоор оршин суух үнэмлэхийг хуурамчаар үйлдсэн эсхүл засварлаж өөрчилсөн гадаадын иргэдэд хариуцлага тооцож эсхүл оршин суух статустай байсан ч албадан гаргана!



Үгүй!

Дунд болон урт хугацааны оршин суугчийн мэдэгдэх үүрэг

- ◆ Дунд болон урт хугацаанд оршин суугчид хотын з ахиргаа, Японд оршин суух хаягийнхаа дагуу харьяалагдах Цагаачлалын алба, харьяалагдах байгууллагадаа (компани, дэлгүүр, сургууль гэх мэт) мэдэгдэх ёстой.



Дунд болон урт хугацаанд оршин суугчид Цагаачлалын хяналт ба дүрвэгсдийг зөвшөөрөх тухай хуульд заасны дагуу мэдэгдэл илгээх ёстой.

- Хаяг, байршил • Нэр, төрсөн огноо, яс үндэс / бүс нутаг, хүйс
 - Харьяа байгууллага (үйл ажиллагааны байгууллага, гэрээ байгуулсан байгууллага) ※
 - Эхнэр, нөхрөөсөө салах, эхнэр/ нөхөр нас барах ※
- ※ Зорилтот этгээдийн тодорхойлсон харьяа байгууллага, эхнэр, нөхөр хоёрын талаарх мэдэгдэл.

Мэдэгдэх үүргээ биелүүлэхгүй байх эсхүл худал мэдүүлэг өгөх нь хариуцлага тооцох эсхүл таны оршин суух статусыг цуцлахад хүргэж болзошгүй юм.

Хэрэв та мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол

- Оршин суух хугацаагаа сунгах зөвшөөрөл авах өргөдөл
- Оршин суух хугацаагаа сунгах зөвшөөрөл авах өргөдөл
- Байнга оршин суух зөвшөөрөл авах өргөдөл гаргасан тохиолдолд танд сөрөг үнэлгээ өгч, хариуцлага тооцож болзошгүй.

- ◆ Та Японд очсоныхоо дараа хаана амьдрах эсхүл оршин суух газраа өөрчлөхөөр шийдвэл хотын захиргаанд шинэ хаягаа бүртгүүлэх шаардлагатай.



Хаягаа шийдэх



Хаягаа өөрчлөх

Оршин суух үнэмлэхээ авахдаа хотын захиргаанд шинэ хаягаа мэдэгдэх шаардлагатай.

- ◆ Хэрэв та гэрлэсэн эсхүл таны нэр, төрсөн огноо, яс үндэс, хүйс өөрчлөгдсөн бол Цагаачлалын албанд нэн даруй мэдэгдэх хэрэгтэй.




Нэр, яс үндэс
гэх мэт өөрчлөлт

Цагаачлалын албанд мэдэгдэл илгээхдээ паспорт, зураг, оршин суух үнэмлэх, таны нэр өөрчлөгдсөнийг нотлох бусад материалаа хавсаргах хэрэгтэй.

◆ Хэрэв та сургуулиа хаясан эсхүл компаниа өөрчилсөн бол Цагаачлалын албанд нэн даруй мэдэгдэх хэрэгтэй.



Сургуулиас гарах,
төгсөх, дэвшин
суралцах, шилжин
суралцах



Ажлаас гарах,
ажил солих

Мэдэгдэл өгөх үүрэгтэй оршин суух статус

Профессор, Мэргэжлийн өндөр ур чадвартай ажилтан, Удирдлага, менежмент, Хууль эрх зүй, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ, Эрүүл мэндийн үйлчилгээ, Боловсрол, Компанийн дотор нүүлгэн шилжүүлэх, Урчадварын дадлагажигч, Гадаад оюутан, Сургалт, Эрдэмшинжилгээ, Технологи, хүмүүнлэгийн мэдлэг, олон улсын ажил, Соёл урлагийн үйлчилгээ, Ур чадвар, Сувилахуйн халамж, Тодорхой чадвар шаардсан ажил

Мэдэгдэлд дараах шалтгааныг дурдах шаардлагатай.

- Сургууль, ажлын газрын харьяаллын нэр, хаяг өөрчлөгдсөн, эсвэл үгүй болсон
- Таны харьяалагддаг сургууль, компани зэрэг байгууллагуудаас авах, шилжүүлэх
- Компани гэх мэт гэрээт байгууллагатай хийсэн гэрээг цуцлах, шинэ гэрээ байгуулах

Мэдэгдэлийн шаардлагыг биелүүлээгүй эсхүл худал мэдүүлэг өгсөн тохиолдолд хариуцлага тооцно.

- ◆ Хэрэв та "Гэр бүлээрээ оршин суух", "Япон иргэний эхнэр, нөхөр", "байнгын оршин суугчийн эхнэр, нөхөр" гэх мэт оршин суух статустай бөгөөд гэр бүл цуцлуулсан эсхүл бэлэвсэрсэн бол Цагаачлалын албанд нэн даруй мэдэгдэнэ үү.



Эхнэр, нөхрөөс
салсан
эсхүл эхнэр,
нөхөр нас барсан

Тайлагнах үүрэгтэй хүн бол эхнэр/ нөхрийн хувьд оршин суух статусын суурь үндэс юм. Бусад хүмүүс зөвшөөрөгдөхгүй. Хэрэв та гэр бүлээ цуцлуулсан эсхүл эхнэр, нөхөр тань нас барсан бол Цагаачлалын алба, хоты н захиргаанд мэдэгдэх ёстой (гэр бүл цуцалсан эсхүл нас барсан тухай мэдэгдэл).

Мэдэгдэх үүргээ биелүүлээгүй эсхүл хуурамч мэдэгдэл өгсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

- ◆ Та өөр байгууллагад ажиллах болсон, гэр бүлээ цуцлуулсан, эсхүл өхнэр, нөхөр нас барсан тохиолдолд интернет ашиглан мэдэгдэх боломжтой.

Энд дарж хайна уу.

Цагаачлалын албаны цахим
мэдэгдлийн систем

Хайлт хийх



https://www.moj.go.jp/isa/publications/materials/i-ens_index.html

Танд ямар нэг асуудал гарвал холбогдох хүний хаяг, утас

◆ Яаралтай онцгой тохиолдолд

Гэмт хэрэг,
осол гарсан
тохиолдолд



Утас: 110

Гал түймэр, өвчин,
гэмтэж бэртсэн
тохиолдолд



Утас: 119

◆ Оршин суух статустай холбоотой асуудлаар мэдээлэл авахад...

Цагаачлалын мэдээллийн төв

Утас: 0570-013904

(Ажлын өдрийн 8:30-17:15)



Япон, Англи, Хятад, Солонгос, Испани, Португал, Вьетнам,
Непал, Тай, Мьянмар, Синхала хэлний сонголттой!

◆ Гадаадын иргэдийн ахуй амьдралтай холбоотой мэдээлэл зөвлөгөө авахад...

Гадаадын Иргэдийн Ахуй Амьдралд Туслах Төв
(Токиогийн Цагаачлалын Алба)

Утас: 03-5363-3025 (Зөвхөн цаг авах)

(Ажлын өдрийн 09:00-17:00)

Цаг авах маягт https://www.moj.go.jp/isa/support/fresc/fresc_2.1.html

Хаяг: Токио Хот, Шинжюкү Дүүрэг Ёцүя 1-6-1, Ёцүя Тауэр 13 давхар



◆ Ахуй амьдралын тухай мэдээлэл, зөвлөгөө авахад...

Токио хотын
Гадаад иргэдэд
зөвлөгөө өгөх төв



Англи, Хятад,
Солонгос хэлний сонголттой

Токиогийн олон хэл
дээр зөвлөгөө өгөх
навигаци руу



Төлбөргүй дугаар
0120-142-142
(14 хэлний сонголттой)

◆ Гадаадын иргэдэд хэрэгтэй мэдээлэл...



TIPS for Tokyo Life
Tokyo Intercultural Portal Site
東京都多文化共生ポータルサイト



Гадаадын оршин суугчдад зориулсан заавар



Энэ зааврыг олон орны хэлээр хөрвүүлсэн болно.

Токид хотын хоумпейжээс үнэгүй татаж авах
боломжтой.

Гадаадын оршин суугчдад зориулсан
заавар

Хайлт хийх



Хэвлүүлсэн: Токио хот

(Nishi-Shinjuku-ku, Shinjuku-ku, Tokyo 163-8001)

☎ 03-5388-2279

2026 оны 3-р сард хэвлэгдэв

印刷物登録番号

リサイクル適性(A)
この印刷物は、印刷用の紙へ
リサイクルできます。

モンゴル語版

(7) 37